

Гэрээний дугаар: Үйлчилгээний салбар: Ажилтны нэр:

БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Өргөдлийн маягтын төрөл: Шинэ хэрэглэгч Эзэмших эрх шилжих Гэрээ шинэчлэх
 Байгууллагын нэр: Регистрийн дугаар:
 Хамтран Ажиллах Гэрээтэй эсэх: Тийм Үгүй
 Байгууллагын албан ёсны хаяг:
 Хот/Аймаг: Дүүрэг/Сум: Хороо/Баг:
 Хороолол/Гудамж: Байр: Тоот:
 Байгууллагын утасны дугаар: И-мэйл хаяг:

Хэрэглэгч би дээрх хаягийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий хуулийн 15.5.1-д заасны дагуу гаргуулан авахыг Скайтел ХХК-д үүгээр зөвшөөрч байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог: Эцэг/эхийн нэр: Нэр
 Регистрийн дугаар: Төрсөн огноо: Эр Эм
 Албан ёсны хаяг:
 Хот / Аймаг: Дүүрэг/Сум: Хороо/Баг:
 Хороолол/Гудамж: Байр: Тоот:
 Одоо оршин суугаа хаяг:
 Хот / Аймаг: Дүүрэг/Сум: Хороо/Баг:
 Хороолол/Гудамж: Байр: Тоот:
 Утасны дугаар: И-мэйл хаяг:
 Яаралтай болон шаардлагатай үед холбоо барих мэдээлэл:
 Овог/нэр: Холбоо барих утас: Таны хэн болох:
 Овог/нэр: Холбоо барих утас: Таны хэн болох:

Яаралтай болон шаардлагатай үед дээрх хүмүүст мэдээлэл хүргүүлэхийг зөвшөөрч байна.

ШИНЭЭР АВЧ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Шинэ дугаарын төрөл: Энгийн Азын Алтан
 Таны сонгосон дугаар:
 Бүртгэлийн хураамж: ₮
МОНГОЛДОО 6.0 багц: 10'000₮ багц 20'000₮ багц 30'000₮ багц 40'000₮ багц 70'000₮ багц 100'000₮ багц
InLive багц: 12'000₮ багц 25'000₮ багц 35'000₮ багц 50'000₮ багц 65'000₮ багц 90'000₮ багц
Байгууллагын багц: 8'000₮ багц

Нэмэлт барьцаа:

Үндсэн барьцаа	Олон улсын яриа	Олон улсын роуминг	Хэрэглээний хязгаар
<input type="checkbox"/> 0₮		0₮*	200,000₮**
<input type="checkbox"/> 20,000₮	<input type="checkbox"/> 100,000₮	100,000₮	200,000₮**
<input type="checkbox"/> 30,000₮	<input type="checkbox"/> 200,000₮	350,000₮	500,000₮**
<input type="checkbox"/> 50,000₮		500,000₮	Хязгааргүй***

*Дугаараа 1 жилээс дээш ашигласан хэрэглэгч

**Үйлчилгээний нөхцөлийн дагуу яриа, мессеж, задгай дата хэрэглээ хязгааргүй

***Хэрэглээ хязгаарлагдахгүй.

ТӨЛБӨР ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах хэлбэр: Мессеж И-мэйл Үйлчилгээний салбар
 Санхүүгийн хариуцлага: Хувь хүн Байгууллага
 Нэхэмжлэх хүлээн авах: Хувь хүн Байгууллага

Миний бие Скайтел ХХК-ийн Дараа төлбөрт үйлчилгээний гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж зөвшөөрсөн, хувийн мэдээллээ үнэн зөв мэдүүлсэн бөгөөд өөрийн талаарх мэдээллийг цуглуулах, ашиглах, бусадтай солилцох эрхийг үйлчилгээ үзүүлэх талд олгосон болохоо баталгаажуулан гарын үсэг зурсан болно.

Дугаар үүссэн огноо: Үйлчилгээ авсан огноо:

Гэрээ байгуулсан ажилтны гарын үсэг: Хэрэглэгчийн гарын үсэг:



ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Энэхүү ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ /цаашид “Гэрээ” гэх/-г Нэг талаас: 2576376 тоот регистрийн дугаартай, 9011269206 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй Монгол Улсын хуулийн этгээд болох “СКАЙТЕЛ” ХХК /цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх/, нөгөө талаас Монгол улсын иргэн РД: _____, _____ /цаашид “Хэрэглэгч” гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ӨРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үүрэн төлбөр холбооны дараа төлбөрт үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/-г үзүүлэх, Хэрэглэгч нь гэрээнд заасны дагуу зохих төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээний үйлчлэх хүрээнд гарах, орох дуудлага, үндсэн болон нэмэлт үйлчилгээ, гарах, орох мессежийн үйлчилгээ, хот доторх болон улс хоорондын үйлчилгээ мөн хөдөлгөөнт интернетийн үйлчилгээгээр үйлчлүүлэх бололцоогоор хангагдана.
- 1.3 Үйлчилгээний дугаар болон сим карт нь үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд гэрээний хүчин төгөлдөр хугацаанд тэдгээрийн зөвхөн эзэмших эрхийг Хэрэглэгчид олгоно.
- 1.4 Гэрээний өргөдлийн маягт болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг, мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудсыг Гэрээтэй хамт хэрэглэх ба эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг байна. Хэрэв дээрх баримт бичиг хоорондоо зөрчилдвөл Гэрээг удирдлага болгоно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь Хэрэглэгч Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээ цуцлагдах хүртэл хугацаанд үйлчилнэ.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 **Хэрэглэгч нь дараах эрхтэй**
 - 3.1.1 Хэрэглэгч нь энэхүү гэрээгээр зөвхөн нэг дугаарыг эзэмших эрхтэй. Нэг Хэрэглэгч 5-аас ихгүй гэрээ байгуулна.
 - 3.1.2 Хэрэглэгч дугаарын дэлгэрэнгүй мэдээлэл авахад зөвхөн өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт ирнэ. Хэрэглэгч өөрийн биеэр ирэх боломжгүй бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлнэ.
 - 3.1.3 Хэрэглэгч нь тодорхой шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн журамд заасан үйлчилгээнүүдийг өргөдлийн маягтад бөлгөсөн баталгаат и-мэйл хаягаас хүсэлт илгээн авах эрхтэй.
 - 3.1.4 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээ, хөнгөлөлт, урамшуулал болон үнэ тарифын талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомж, Үйлчилгээ үзүүлэгчийн дүрэм, журам, үйлчилгээний нөхцөлийн хүрээнд авах эрхтэй.
 - 3.1.5 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргах, талархал илэрхийлэх эрхтэй.
- 3.2 **Хэрэглэгч нь дараах үүрэгтэй**
 - 3.2.1 Хэрэглэгч нь өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөх үүрэгтэй.
 - 3.2.2 Өргөдлийн маягтад тусгасан Хэрэглэгчийн холбогдох утасны дугаар, гэрийн хаяг болон бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.
 - 3.2.3 Үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, Гэрээ болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийн дагуу ашиглах үүрэгтэй.
 - 3.2.4 Хэрэглэгч гэрээний 3.1.3-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ гэрээний өргөдлийн маягтад бөлгөсөн баталгаат и-мэйл хаягаас үйлчилгээ авах хүсэлт илгээхдээ баталгаат гарын үсэгтэй өргөдлийг хавсарган, Үйлчилгээ үзүүлэгчийн журамд заасан нөхцөлийн дагуу үйлчилгээ авах үүрэгтэй.
 - 3.2.5 Хэрэглэгч нь баталгаат и-мэйл хаяг болон гар утсан дахь мэдээллийн хуудсаа, аюулгүй байдлаа хангах үүрэг хүлээнэ. Нууцлал, аюулгүй байдлыг хангааруулах улмаас үүдэн гарах аливаа хохирол үр дагаврыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
 - 3.2.6 Өмнөх сард ашигласан үйлчилгээний төлбөрийг дараа сарын 05-ны өдрөөс 20-ны өдрийн дотор бүрэн төлөх үүрэгтэй.
 - 3.2.7 Хэрэглэгч сим карт бүхий гар утсаа эсвэл сим картаа алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төвд хандан үйлчилгээгээ түр хаалгах үүрэгтэй.
 - 3.2.8 Хэрэглэгч нь сим картаа гэрээнд заасны дагуу ашиглах, зүй зохистой бус хэрэглээ хийхгүй байх үүрэгтэй.
 - 3.2.9 Хэрэглэгч бусдаар дамжуулан Тан кодоор үйлчилгээ авахгүй байх үүрэгтэй ба үүрэгээ биелүүлээгүйгээс гарсан хохирлыг Хэрэглэгч өөрөө хариуцна.
 - 3.2.10 Энэхүү гэрээний 4.1.3-т заасан Үйлчилгээ үзүүлэгчийн мэдэгдэлтэй тухай бүр танилцах үүрэгтэй.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 **Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй**
 - 4.1.1 Хэрэглэгчийн хэрэглээ нь хэрэглээний хязгаараас хэтэрсэн тохиолдолд задгай яриа, мессеж, дата хэрэглээ нь хэрэглээ хязгаарлах түвшинд хүрсэн бол төлбөр нэхэмжлэх хугацаанаас үл хамаарч үйлчилгээ хаагдана.
 - 4.1.2 Хэрэглэгч нь зүй зохистой бус хэрэглээ хийсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч сануулах хүргэх, Хэрэглэгчийн үйлчилгээг хаах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
 - 4.1.3 Үйлчилгээ үзүүлэгч нь зах зээлийн нөхцөл байдал, төрийн байгууллагын шийдвэр болон бүтээгдэхүүн, Үйлчилгээг ашигжуулах болон бусад шалтгааны улмаас Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөл, үнэ тариф болон Гэрээнд нэг талын санаачилгаар нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Энэ тухай Хэрэглэгчид хуанлийн 30 хоногийн өмнө мессежээр, үйлчилгээний салбаруудаар эсвэл www.skytel.mn цахим хуудасны аль нэгээр мэдэгдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдэгдэнэ.
 - 4.1.4 Хэрэглэгч нь ийнхүү мэдэгдсэнээ хойш өөрчлөгдсөн нөхцөлийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар ажлын 10 хоногийн дотор мэдэгдээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн саналыг буюу гэрээний нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцож ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөл, үнэ тариф болон гэрээний нэмэлт, өөрчлөлттэй танилцаагүй мэдээгүй нь төлбөр төлөх үүрэг болон бусад үүрэгээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
 - 4.1.5 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр Хэрэглэгчийн гарч хэрэглээг барьцаанаас хамааруулан хязгаарлах эрхтэй. Үүнд:
 - 4.1.5.1 Гадаадын иргэн бол;
 - 4.1.5.2 Задгай хаягтай бол;
 - 4.1.5.3 Цахим үнэмлэхийн хүчинтэй хугацаа дууссан бол;
 - 4.1.6 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үндэслэлээр Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр үйлчилгээний эрхийг хаах эрхтэй. Үүнд:
 - 4.1.6.1 Төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол;
 - 4.1.6.2 Өргөдлийн маягтын мэдээллийг санаатайгаар худал мэдүүлсэн эсхүл 3.2.2-т заасан үүрэгээ биелүүлээгүй бол;
 - 4.1.6.3 Хэрэглэгч гэрээнд тусгасан хаяг дээрээ оршин суудаггүй болох нь тогтоогдсон бол;
 - 4.1.6.4 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай бол;
 - 4.1.7 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд өр авлага барагдуулах зорилгоор гуравдагч этгээдэд Хэрэглэгчийн талаарх болон гэрээний тухай мэдээллийг өгөх, шалгуулах, төлбөр төлөхийг шаардах эрхийг шилжүүлэх эрхтэй.
 - 4.1.8 Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд төлбөрийн маргаантай бол Хэрэглэгчтэй дахин аливаа үйлчилгээний гэрээ байгуулахаас татгалзах эрхтэй.
 - 4.1.9 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд авлага барагдуулах зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хуулийг үндэслэн зээлийн мэдээллийн санд төлбөрийн ангиллыг бүртгүүлэх мөн түүнчлэн хууль тогтоомжид заасны дагуу бусад арга хэмжээг авах эрхтэй.
- 4.2 **Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй**
 - 4.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үйлчилгээг өөрийн техникийн боломж болон хүчин чадлын хүрээнд чанарын өндөр түвшинд үзүүлнэ.
 - 4.2.2 Хэрэглэгчийн хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг гэрээ байгуулсан тухайн дугаарын эзэмшигчид цахим үнэмлэх, байгууллагын албан тоот хүсэлтийг үндэслэн олгоно.
 - 4.2.3 Хэрэглэгчийн сар бүрийн хэрэглээний төлбөрийн нэхэмжлэлийг Гэрээнд заасан и-мэйл хаяг, мессежийн аль нэгээр Хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.
 - 4.2.4 Алслагдмал нутаг, нам дор эсвэл уулархаг газар, зузаан бетонон ханан доторх барилга байгууламжид, зарим нэг автомат өгсгөд шат (лифт) дотор болон зарим этгээдийн санаатай үйлдэл, тусгай тоног төхөөрөмж (долгон сааруулагч тусгай хэрэгсэл)-с шалтгаалж сүлжээ тасалдаж болно.
 - 4.2.5 Хэрэглэгчийн тоног төхөөрөмж, гар утас нь Үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээнд ашиглах боломжтой, холбогдох стандартын шаардлага хангасан, Үйлчилгээний зохиц шалтгаалд нийцсэн байх ёстой.
 - 4.2.6 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгч болон гуравдагч этгээдээс хамаарсан сүлжээний тасалдал, механик гэмтэл, тог ажилгааны хэлбэлзлээс үүссэн аливаа үр дагаврыг хариуцахгүй.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Хэрэглэгч нь гар утсаа алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд үйлчилгээг түр хаалгах хүсэлтээ өгөх хүртэлх

- хугацааны үйлчилгээний төлбөрийг бүрэн хариуцна.
- 5.2 Хэрэглэгч нь дугаар ашиглах эрхээ Үйлчилгээ үзүүлэгчид албан ёсоор хандан гэрээний үндсэн дээр шилжүүлэхээс бусад байдлаар дүр мэдэн гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол түүнээс үүдэн гарах хохирлыг бие даан бүрэн хариуцна.
- 5.3 Хэрэглэгч дугаараа эсхүл гар утсаа гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдалаар дамжуулсан, ашиглуулсан, аль нэг програмыг буруу ажиллуулсан эсвэл энэхүү гэрээний 3.2.8-д заасан үүрэгээ зөрчсөнөөс үүсэн гарах аливаа үр дагавар, хохирол, зардлыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
- 5.4 Хэрэглэгч өөрийн биеэр ирж гэрээ байгуулах тохиолдолд өөрийн баталгаат гарын үсгийг заавал зурах үүрэгтэй ба гарын үсгийн баталгаат хуудас нь дараа төлбөрт үйлчилгээний гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.5 Энэ гэрээний 5.4-т заасан баталгаат гарын үсгийг Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчийн төхөөрөмж дээр хуулбарлан буулгаж зурснаар дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулсанд тооцно.
- 5.6 Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний өргөдлийн маягтад өгөгдсөн мэдээлэл болон үйлчилгээний гэрээ, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг өөрийн нууцад хамааруулан хадгалах бөгөөд дараах тохиолдлуудад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй. Үүнд:
 - 5.6.1 Хэрэглэгч гэрээний үүрэгээ биелүүлээгүйгээс үүссэн авлагыг барагдуулах зорилгоор;
 - 5.6.2 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шаардсанаар;
 - 5.7 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авах аливаа үйлдэл хийсэн, тийнхүү олж авсан мэдээллийг хувийн болон бусад зорилгоор ашигласан, хэрэглэсэн, дамжуулсан, задруулсан бол энэхүү үйлдлийн улмаас учирсан эсхүл болох аливаа хохирлыг бүрэн хариуцахын зэрэгцээ хуульд заасан бусад хариуцлага хүлээнэ.
- 5.8 Хэрэглэгчийн дугаарт дуудлага, мессеж болон онлайн сувгаар (Скайтел аппликэйшн, веб хуудас, фэйсбүүк мессенжер, цахим хаяг)-аар дамжуулан санал болгосон багц өөрчлөх, гэрээ шинэчлэх үйлчилгээний нөхцөлийг Хэрэглэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэлцэл хийсэнд тооцно.
- 5.8.1 Хэрэглэгчийн дугаарт илгээгдсэн баталгаажуулах код бүхий мессеж болон онлайн суваг, дуудлагын төвийн бүртгэл зэрэг нь хэлцэл хийснийг нотлох баримт болно.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

- 6.1 Үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээний төлбөрийг сар бүрийн 01-ний өдрөөс 31-ний өдрөөр тасалбар болгон дараа сарын 05-ны өдрийн дотор Хэрэглэгчээс нэхэмжилнэ.
- 6.2 Хэрэглэгч хэрэглээ хязгаарлах үйлчилгээ идэвхжүүлсэн тохиолдолд задгай яриа, мессеж, дата хэрэглээ нь хэрэглээ хязгаарлах түвшинд хүрсэн бол төлбөр нэхэмжлэх хугацаанаас үл хамаарч үйлчилгээ хаагдана.
- 6.3 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын суурь хураамж, сарын хэрэглээний дүнгээс зохих хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүн, төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
- 6.4 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчийн заасан дансанд, үйлчилгээний салбарт бэлнээр, мобайл банк, www.skytel.mn болон бусад боломжит сувагаар төлнө.
- 6.5 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн сарын 20-ны өдрийн дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 6.6 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрөө цаг тухайд нь төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг бүрэн хааснаас хойш Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийн дагуу барьцаа төлбөрөөс Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг суугтах эрхтэй.
- 6.7 Төлбөр төлөөгүйн улмаас хаагдсан дугаарт төлбөрийг бүрэн төлөгдөх хүртэл бусад үйлчилгээг үзүүлэхгүй.
- 6.8 Хэрэглэгч гэрээг буюу дугаарыг цуцлах өдрийг хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.9 Гэрээний 6.1-д заасан хугацаанд төлбөр нэхэмжлээгүй эсхүл үйлчилгээг хаагаагүй нь төлбөр төлөх үүрэгээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.10 Үйлчилгээ үзүүлэгч төлөгдөөгүй төлбөрийг барагдуулахтай холбогдон гэрээн нэмэлт зардлыг Хэрэглэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 6.11 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үлдсэн төлбөрийн 0.5%-тай тэнцэх алданги тооцож нэхэмжлэх эрхтэй.
- 6.12 Хэрэглэгчийн барьцаа төлбөр нь нийт төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй бол Үйлчилгээ үзүүлэгч үлдгэдэл төлбөрийг нэхэмжлэх эрхтэй.
- 6.13 Барьцаа төлбөр байршуулаагүй нь Хэрэглэгч хэрэглээний төлбөрийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.
- 6.14 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс авсан аливаа үйлчилгээ төлбөрийг хугацаандаа барагдуулаагүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн бусад үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэх дээр нэмж нэхэмжлэх болон үйлчилгээг хязгаарлах эрхтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал гал түймэр, үер, хүр тунадас болон шороон шуурга, газар хөдлөлт, аянга цахилгаан, галт уулын болон бусад тэсрэлт, дэлбэрэлт, цаг агаарын хэт халалт ба хүйтрэлт эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цэзрийн дэглэм, гоц халдвар өвчин, ажил хаялт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, дайн /Зарлагдсан болон зарлагдаагүй/, террорист халдлага, түлш, эрчим хүчний хязгаарлалт, сүлжээний хэт ачаалал, доголдол, тасалдал болон зэвсэгт гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас Талууд гэрээгээр хүлээсэн үүрэгээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээгээр.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд гэрээг цуцлах талаар саналаа албан ёсоор бичгээр гаргах эрхтэй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэх чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.2 Хэрэглэгч гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хэрэглэгч өргөдлийн маягт түүнд агуулагдсан мэдээллийг үнэн зөв өгч, Талууд энэхүү гэрээний нөхцөлд заасан бүхий л заалтууд болон Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

ГЭРЭЭГ БАТАЛСАН УДИРДЛАГА:	
.....
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
.....
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН:	ОВОГТОЙ:
.....
Гарын үсэг:
.....
Тамга:

Гэрээ байгуулсан огноо: 20..... оны сарын өдөр